



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 26 өдөр

Дугаар A/17.

Улаанбаатар хот


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах заалт, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/120 дугаар захирамж, Газрын дүрмийн 2.5.3-т заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Холбооны Бүгд найрамдах Герман Улсын Берлин хотод зохион байгуулагдах “Ай Ти Би Берлин-2019” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд нэгдсэн зохион байгуулалттай оролцох ажлыг орлогч дарга /Ц.Энхтүвшин/-д даалгасугай.

2. Гадаад томилолтод шаардагдах хөрөнгийг Нийслэлийн 2019 оны төсөвт тусгасан “Зүүн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болох арга хэмжээ”-ний зардлаас хавсралтад дурдсаны дагуу санхүүжүүлэхийг Нягтлан бодогч /Батцож/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА *D. Batsukh* Д.БАТСҮХ



1150500103

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 02
сарын 26-ны өдрийн А/17 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

“АЙ ТИ БИ БЕРЛИН-2019” ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЗЭСГЭЛЭНД
ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Хугацаа: 2019 оны 03 дугаар сарын 03-14-ний өдрүүд

№	Зардлын төрөл	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Тооцоо хийх хэлбэр	Хянасан
1	Нислэгийн тийз	11 хүн	1 500 000 төгрөг	16 500 000 төгрөг	Нэхэмжлэх	16 500 000
2	Зочид буудал	3 хүн*4 хоног 4 хүн*11хоног 4 хүн*7 хоног	160 ам.доллар	1 920 7 040 4 480 ам.доллар	Бэлнээр	1 920 7 040 4 480 ам.доллар
3	Визний хураамж	10 хүн	180 000 төгрөг	1 800 000 төгрөг	Бэлнээр	1 800 000 төгрөг
4	Зам хоног	3 хүн*4 хоног 4 хүн*11хоног 4 хүн*7 хоног	50 ам.доллар	600 2 200 1 400 ам.доллар	Бэлнээр	600 2 200 1 400 ам.доллар
5	Даатгалын хураамж	10 хүн	41 900 төгрөг	419 000 төгрөг	Бэлнээр	419 000 төгрөг
6	Үзэсгэлэнгийн талбайн түрээс	40 м2	10 550 евро	10 550 евро	Нэхэмжлэх	9300 евро
7	Үзэсгэлэнгийн мандат	11 хүн	60 евро	660 евро	Бэлнээр	660 евро
8	Сэтгүүл хэвлүүлэх зардал /80 хуудас/	1 500 ширхэг	4 000 төгрөг	6 000 000 төгрөг	Нэхэмжлэх	6 000 000 төгрөг
9	Сэтгүүлийн эх бэлтгэл, орчуулгын зардал	-	400 000 төгрөг	400 000 төгрөг	Нэхэмжлэх	400 000 төгрөг
10	Тээврийн түрээсийн зардал	6 өдөр	300 евро	1 800 евро	Бэлнээр	1 800 евро
11	Бэлэг дурсгал	-	13 500 000	13 500 000 төгрөг	Нэхэмжлэх	13 500 000
НИЙТ: 38 619 000 /гучин найман сая зургаан зуун арван есөн мянга/ төгрөг, 17 640 /арван долоон мянга зургаан зуун дөч/ ам.доллар, 11 760 /арван нэгэн мянга долоон зуун жар/ евро. Гадаад валютыг тухайн өдрийн Монгол банкны ханшаар тооцно.						